



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/44/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас:99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.08.27 № 189

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.ИДЭРМӨНХ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020140

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Идэрмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.10-аас 2020.02.11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.06-ний өдрийн № А/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутгийн төсөвт байгууллагууд болон төрийн өмчийн ОНӨҮГ-ын Өмч хөрөнгийн харилцааг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд зохицуулах мөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж бүх шатны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт үр ашиг ил тод байдал харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж авлига гарах нөхцөлийг бууруулах дотоодын үйлдвэрлэгч гүйцэтгэгчийг дэмжих шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг хурдасгахад дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилго оршино.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Орон нутгийн өмч хөрөнгийг хамгаалах, шилжүүлэх, актлах гэх мэт харилцааг зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5-д болон 48.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн захиалгыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагааг энэхүү хууль, журмын хүрээнд зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 28 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1123642,8 мянган төгрөгөөс тооцон 22472,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 22472,9 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 869554,3 мянган төгрөгөөр буюу 7,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	-	17.8	17.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	7,410.1	34,471.9	27,061.8
Үндсэн хөрөнгө	11,944,756.0	12,013,122.1	68,366.1
Хуримтлагдсан элэгдэл	(521,947.4)	(1,486,947.4)	(965,000.0)
Нийт хөрөнгө	11,430,218.7	10,560,664.4	(869,554.3)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,430,218.7	10,560,664.4	(869,554.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,430,218.7	10,560,664.4	(869,554.3)

Авлага дансны үлдэгдэл 17,8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМНДШ-ийг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27061,8 мянган төгрөгөөр өссөн гол шалтгаан нь бараа материалын дансанд 30000.0 мянган төгрөгөөр Онцгой байдлын газарт авсан автомашины санхүүжилтийг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 869554.3 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь тайлант онд 965000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулагдсантай холбогдолтой байна. Мөн УЦУОШГ 32000,0 мянган төгрөгөөр, Шүүхийн шинжилгээний газар 30800,0 мянган төгрөгөөр автомашин авч хөрөнгөд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5460740,3 мянган төгрөг болж 869554,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүн байна.

Нэмэлт санхүүжилтээр ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тайлант онд өөрийн орлого 30000,0 мянган төгрөг төлөвлөснөөс 17461,6 мянган төгрөг төвлөрүүлсний 15048,0 мянган төгрөг нь цахим тендерийн орлого, 2413,6 мянган төгрөг нь дуудлага худалдаа зохион байгуулсны орлого орсон байна.

Тайлант онд нийт 180531,9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсаны 150531,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Урсгал зардалд 172492,9 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч оны эцэст 513,5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгийн дуудлага худалдааны орлогоор 50000,0 мянган төгрөг төлөвлөгдөж байгууллагын үндсэн дансаар 73602,8 мянган төгрөгийн орлого орсноос орон нутгийн орлогод 68589,8 мянган төгрөг төвлөрүүлж, 5013,0 мянган төгрөгийг хөрөнгийн үнэлгээний компанид олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 172493,0 мянган төгрөг буюу 95,5 хувьтай байгаа нь өөрийн орлогын төлөвлөгөө 12538,4 мянган төгрөгөөр биелээгүйгээс, цалингийн зардал 13051,5 мянган төгрөгийг зарцуулах эрх нээгдээгүйтэй холбоотой байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 725,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 325,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 400,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	400,0	
2	Төлбөрийн акт	1	325,0	
	Дүн	2	725,0	

Аудитаар 1194,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэнд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. 2019.12.23-нд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд 325,0 мянган төгрөгийн томилолт олгосон боловч тухайн мэргэжилтнийг томилолтоор ажиллах удирдамжгүй, ирж очсон замын зардлын баримт байхгүй, томилсон тухайн өдрүүдэд ажлын байранд ажилласан цаг бүртгэгдсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, " Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд нийт 151 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	9	2	0
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
6	Нийт	27	151	149	2	0

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 2550,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 1 зөвлөж өгсөн бөгөөд хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл*

1.1. Илрүүлэлт:

Цалингийн тооцооллыг давтан шалгахад НДШ-д 400,0 мянган төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй

1.3. Өгсөн зөвлөмж:

НДШ-ийн зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,410,149.00</u>	<u>34,489,629.38</u>
33	АВЛАГА	00.00	17,750.38
335	Бусад авлага	00.00	17,750.38
3351	Байгууллагаас авах авлага	00.00	17,750.38
35	БАРАА МАТЕРИАЛ	7,410,149.00	34,471,879.00
354	Хангамжийн материал	7,410,149.00	34,471,879.00
35410	Бичиг хэргийн материал	605,999.00	385,479.00
35420	Аж ахуйн материал	3,264,900.00	4,086,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,660,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	879,250.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	30,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,422,808,573.12</u>	<u>10,526,174,786.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,422,808,573.12	10,526,174,786.37
392	Биет хөрөнгө	11,422,808,573.12	10,526,174,786.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,101,428,252.71	11,101,428,252.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-834,764,648.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	740,812,390.06	803,612,390.06
39204	Хуримтлагдсан элэгдэл	-487,119,371.44	-610,588,103.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,922,771.60	30,762,571.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,668,651.21	-23,293,160.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,502,970.00	15,229,270.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,103,145.11	-8,188,075.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,321,341.50	61,321,341.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,606,284.99	-9,663,351.95
39217	Ном	318,300.00	318,300.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,430,218,722.12</u>	<u>10,560,664,415.75</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,430,218,722.12</u>	<u>10,560,664,415.75</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,430,218,722.12	10,560,664,415.75
512	Хуримтлагдсан үр дүн	6,330,294,631.64	5,460,740,325.27
51210	Өмнөх үеийн үр дүн	6,330,294,631.64	6,330,294,631.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-869,554,306.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,099,924,090.48	5,099,924,090.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,430,218,722.12</u>	<u>10,560,664,415.75</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	213,900,494.00	334,396,182.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,960,290.00	183,864,382.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,960,290.00	183,864,382.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,960,290.00	183,864,382.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,655,890.00	91,064,382.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,400.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,242,000.00	92,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,940,204.00	150,531,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	107,245,400.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,245,400.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	150,531,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	150,531,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,694,804.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,694,804.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	734,280,176.13	1,203,950,488.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	734,280,176.13	1,203,950,488.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,568,201.51	1,134,247,269.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,062,802.00	111,578,816.59
210101	Үндсэн цалин	97,062,802.00	111,578,816.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,801,547.75	14,273,546.43
210201	Тэтгэврийн даатгал	7,987,898.75	9,764,359.61
210202	Тэтгэмжийн даатгал	993,191.00	1,154,449.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	784,953.00	901,317.31
210204	Ажилгүйдлийн даатгал	182,837.00	221,881.35
210205	Эрүүл мэндийн даатгал	1,852,668.00	2,231,538.77
2104	Хангамж, бараа материалын зардал	8,372,231.00	11,208,369.50
210401	Бичиг хэрэг	3,633,700.00	4,170,520.00
210402	Тээвэр, шатахуун	3,652,550.00	5,411,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,981.00	1,276,299.50
210404	Ном, хэвлэл	00.00	350,500.00
2105	Нормативт зардал	00.00	3,158,400.00
210502	Хоол, хүнс	00.00	3,158,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	5,181,000.00
210604	Урсгал засвар	00.00	5,181,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,109,500.00	7,811,800.00
210702	Дотоод албан томилолт	4,109,500.00	7,811,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,579,625.00	15,035,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,146,200.00	14,541,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	158,400.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	113,005.00	152,810.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,020.00	141,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	526,642,495.76	965,999,886.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	525,642,495.76	964,999,886.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,711,974.62	69,703,219.10

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,694,804.00	600,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,694,804.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	68,589,822.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	68,589,822.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	78,017,090.00	513,397.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,017,090.00	513,397.10
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80.62	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80.62	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-520,379,682.13	-869,554,306.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,199,453,793.37	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	235,582,383.91	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	963,871,409.46	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,199,453,793.37	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,719,833,475.50	-869,554,306.37

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	211,596,094.00	241,596,182.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,655,890.00	91,064,382.00
120	Нийтлэг татварын бус орлого	101,655,890.00	91,064,382.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,655,890.00	91,064,382.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,655,890.00	91,064,382.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	109,940,204.00	150,531,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	107,245,400.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,245,400.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	150,531,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	150,531,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,694,804.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,694,804.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	211,256,194.00	241,596,182.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,256,194.00	241,596,182.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	130,544,219.38	170,992,962.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,923,849.38	111,078,813.40
210101	Үндсэн цалин	73,020,049.38	86,542,513.40
210102	Нэмэгдэл	16,005,800.00	16,550,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,898,000.00	7,986,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,696,764.00	13,891,300.00
210201	Тэтгэврийн даатгал	7,945,515.00	9,439,878.74
210202	Тэтгэмжийн даатгал	993,191.00	1,201,813.29

**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210203	ҮОМШӨ-ний даатгал	722,553.00	804,706.33
210204	Ажилгүйдлийн даатгал	182,837.00	222,301.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,852,668.00	2,222,600.58
2104	Хангамж, бараа материалын зардал	9,374,481.00	10,526,099.50
210401	Бичиг хэрэг	3,726,700.00	4,203,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,531,800.00	4,531,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,085,981.00	1,439,999.50
210404	Ном, хэвлэл	30,000.00	350,500.00
2105	Нормативт зардал	00.00	3,500,000.00
210502	Хоол, хүнс	00.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,660,000.00	8,722,100.00
210602	Тавилга	00.00	5,676,100.00
210604	Урсгал засвар	1,660,000.00	3,046,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,109,500.00	7,811,800.00
210702	Дотоод албан томилолт	4,109,500.00	7,811,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,779,625.00	14,462,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,346,200.00	13,968,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	158,400.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	113,005.00	152,810.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,020.00	141,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,711,974.62	70,603,219.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,694,804.00	1,500,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,694,804.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	68,589,822.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	68,589,822.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	78,017,090.00	513,397.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,017,090.00	513,397.10
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80.62	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80.62	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>339,900.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	339,900.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	339,900.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	339,900.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	339,900.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-339,900.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	6,330,294,631.64	00.00	11,430,218,722.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	6,330,294,631.64	00.00	11,430,218,722.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-869,554,306.37	00.00	-869,554,306.37
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	5,099,924,090.48	5,460,740,325.27	00.00	10,560,664,415.75

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,245,000.00	130,884,119.38	180,531,900.00	172,492,962.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,245,000.00	130,884,119.38	180,531,900.00	172,492,962.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,245,000.00	130,884,119.38	179,031,900.00	170,992,962.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,606,900.00	96,923,849.38	124,130,300.00	111,078,813.40
210101	Үндсэн цалин	73,615,100.00	73,020,049.38	99,594,000.00	86,542,513.40
210102	Нэмэгдэл	16,005,800.00	16,005,800.00	16,550,300.00	16,550,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	7,898,000.00	7,986,000.00	7,986,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,097,400.00	11,696,764.00	13,891,300.00	13,891,300.00
210201	Тэтгэврийн даатгал	8,182,800.00	7,945,515.00	9,446,400.00	9,439,878.74
210202	Тэтгэмжийн даатгал	978,700.00	993,191.00	1,111,200.00	1,201,813.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	782,900.00	722,553.00	889,000.00	804,706.33
210204	Ажилгүйдлийн даатгал	195,700.00	182,837.00	222,300.00	222,301.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,957,300.00	1,852,668.00	2,222,400.00	2,222,600.58
2104	Хангамж, бараа материалын зардал	9,391,800.00	9,374,481.00	10,526,100.00	10,526,099.50
210401	Бичиг хэрэг	3,420,000.00	3,419,851.00	4,214,300.00	4,203,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,531,800.00	4,531,800.00	4,531,800.00	4,531,800.00


**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,000.00	1,422,830.00	1,440,000.00	1,439,999.50
210404	Ном, хэвлэл			340,000.00	350,500.00
2105	Нормативт зардал	-	-	3,500,000.00	3,500,000.00
210502	Хоол, хүнс			3,500,000.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,999,900.00	8,722,190.00	8,722,100.00
210602	Тавилга			5,676,190.00	5,676,100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,900.00	3,046,000.00	3,046,000.00
2107	Томилголт, зочны зардал	4,150,000.00	4,109,500.00	7,811,800.00	7,811,800.00
210702	Дотоод албан томилолт	4,150,000.00	4,109,500.00	7,811,800.00	7,811,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,998,900.00	5,779,625.00	9,450,210.00	14,462,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,300,000.00	5,229,720.00	8,955,900.00	13,968,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	158,400.00	158,400.00	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	262,000.00	113,005.00	152,810.00	152,810.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,500.00	256,500.00	141,500.00	141,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	1000000.00	1000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	1500000.00	1500000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	1,500,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			1,500,000.00	1,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,245,000.00	130,884,119.38	180,531,900.00	167,479,962.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,245,000.00	107,245,400.00	150,531,900.00	150,018,402.90
132001	Орон нутгийн төсвөөс	107,245,000.00	107,245,400.00	150,531,900.00	150,018,402.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000.00	23,638,719.38	30,000,000.00	17,461,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000.00	23,638,719.38	30,000,000.00	17,461,560.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	10.00	10.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	02.00	02.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:



Б.АЗБАЯР 2020.02.27

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



А.ЦЭЭНЯМ 2020.02.27

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.27